

Хот байгуулалт Төлөвлөлтийн газар

1929 онд хэвлэх үйлдвэрийн өргөтгөл, 1930-1931 онд автомеханик завод 1933-1938 онд аж үйлдвэрийн комбинатын зарим фабрик завод гэх мэтчилэнгээр улс орны хөгжилт, шаардлага, нийслэл хотыг хөгжүүлэх ойрын ба хэтийн төлөвлөгөөнд уялдуулан олон арван орд харш, үйлдвэр, соёл, гэгээрэл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах, тээвэр холбоот худалдаа, нийтийн хоол, орон сууц, ахуйн үйлчилгээний орчин цагийн ур хийцтэй олон зуун барилга байгууламж баригдаж нийслэл хотыг цогцлон босгосон юм

1930-6-21-нд Засгийн газрын эрхлэх товчооны 36 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын байгуулалтыг эмхтгэх тухайн төлөвлөгөөг зүйтэй гэж үзээд / хашаа байшин дугаарлах/ нийт зхиргааны байгууллагыг шинэчлэн эмхтгэх төлөвлөгөөнд нийлүүлэн гйүцэтгэхээр тогтоожээ.

1936-4-3-нд сайд анрын Зөвлөлийн 20 дугаар хурлын 2 дугаар зүйлээр Улаанбаатар хотын захиргааны дэргэд байгуулагдах байрилгыг хянах товчоо нь барилгын ажлыг нэгдсэн нарийн бодлоготой явуулахыг заагаад үүний урьд томилогдсон Довчин даргатай барилгын комисс хэвээр үлдэж хотын барилгын товчооны ажлыг ерөнхийд нь хянан удирдаж байвал зохино гэжээ.

1936-10-15-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдын 189 дүгээр тушаалаар Улаанбаатар хотын барилга байгуулалт хийгээд бүхийл хөгжил байдлын талаар цаашид хэрхэн, ямар журамтай хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг 1937 оны 3 дугаар сарын дотор, хотын бүхий л байдлыг багтаасан зургийг 1936 оны 12 дугаар сарын дотор үйлдэж гаргахаар тогтоожээ.

1936 оны 10 дугаар сард хотын зураг төлөвлөгөөг шинээр үйлдүүлэх инженерийн ангийг байгуулж хотыг нэгдсэн зураг төлөвлөгөөтэй хөгжүүлэх анхны төслийг инженер Н.Н. Васильевын оролцоотойгоор 1938 онд гаргаж, уг төлөвлөгөөг 1938-4-1-нд Сайд нарын Зөвлөлийн хурлаар үндсэнд нь баталжээ

1938-4-1-нд Сайд анрын Зөвлөлийн II дүгээр хурлын 2 дугаар зүйлээр Улаанбаатар хотыг мод тарьж ногооруулах, хотын байдлыг тохижуулах, сайжруулан өөрчлөх талаар хот сайжруулах комиссын илтгэлийг сонсоод хотыг сайжруулах ерөнхий чигийг зааж ерөнхий зураг гаргахаар тогтоожээ

Улаанбаатар хотын барилга засвар, барилгыг бариулахын тулд барилга засварын конторыг хотын захиргааны харьяанд байгуулахаар тогтоожээ.

1945-5-18-нд сайд нарын Зөвлөл, Намын Төв хорооны 31/27 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Улсын төлөвлөгөөний газраас Улаанбаатар хотын төв хэсгийн зохион байгуулалтын тухай боловсруулсан зураг төлөвлөгөөг батлаад хотыг сайжруулах талаар чухал арга хэмжээнүүд авчээ.

1946-8-2-нд сайд нарын Зөвлөлийн 47 дугаар хурлын 2 дугаар зүйлээр нийслэл Улаанбаатар хотын цаашдын хөгжлийн төлөвлөгөөг баталжээ

1950-5-12-нд сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 108/22 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг боловсон тохилог болгох арга хэмжээний тухай хэлэлцэж чухал арга хэмжээнүүдийг заажээ.

- Хотыг шинэтгэн хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө гргэх Төв халуун ус бариулах

- Хороо, хорьдын нутаг дэвсгэрийг зааглан тогтоох

- Байшин барилгыг дугаартай болгох гэх мэт

1954-8-27-нд Сайд нарын Зөвлөлийн 435 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг хөгжүүлэх, барилгажуулах төлөвлөгөөг баталжээ.

Мөн төлөвлөгөөг зохиох төлөвлөлтийн ба геодезийн хэсгийн зөвлөлтийн мэргэжилтэн нар ажилласан бөгөд ажлын удирдагч, төлөвлөгөөний инженер А. В. Дценко байжээ.”

1958-6-25-нд сайд нарын Зөвлөлийн 202 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяанд хот цэцэрлэгжүүлэх конторыг байгуулахаар тогтоожээ.

1960 онд Төлөвлөгөөний талаар тавьсан илтгэлд Улаанбаатар хотод жилд 70000 хавтгай дөрвөлжин метр сууцны талбайтай байшин үйлдвэрлэх чадалтай заводыг барьж эхэлнэ гэжээ.

1961-8-9-нд Сайд нарын Зөвлөлийн 417 дугаар тогтоолоор РТФСР-ийн барилгын хорооны харьяа хотуудын зургийг төлөвлөх улсын институтийн зохиосон Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө нь орчин үеийн социалист хот, суурин газрыг төлөвлөх ба баригажуулах үндсэн зарчмуудад тохирч байгааг тэмдэглээд Улаанбаатар хотын төлөвлөлтийн зураг төсөл/ерөнхий төлөвлөгөө/ ба түүний гол үндэслэлүүдийг баталжээ.

1964-7-15-нд Сайд нарын Зөвлөлийн 342 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын архитектурын газарт засварын төсвийн группийг аж ахуйн тооцооны үндсэн дээр байгуулан ажиллуулахаар тогтоожээ.

1964-11-5-нд Сайд нарын Зөвлөлийн 488 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын архитектурын газарт барилгын техникийн баримт бичгийн архив байгуулахаар тогтоожээ.\

1966-3-16-нд Сайд нарын Зөвлөлийн 81 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын барилга засварын конторыг 1966 оны 3 дугаар улиралд аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллах хотын засварын трест болгон өргтөгөн байгуулжээ

1966-7-4-нд Сайд нарын Зөвлөлийн 144 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотод байгуулагдаж байгаа “хүүхэд залуучуудын соёл амралтын парк”-ийг 1966-7-10-нд нээхээр тогтоожээ.

Улаанбаатар хотын хөгжлийн ирээдүйн төлөвийг 1961 онд батлагдсан шинэ ерөнхий төлөвлөгөө / 1961-1980 он/ гэрэлтүүлэн зааж байна. Энэ төлөвлөгөөгөөр нийслэл хот төв, баруун, зүүн үйлдвэрийн томоохон 4 хэсэгт хуваагдан 19 микро район болон байригажих юм.

Хотын төвийн хэсэгт улсын ба хотын чанартай засаг захиргаа, нийгэм соёл ахуйн томоохон газрууд, аж үйлдвэрийн районд, нийслэлийн үйлдвэрүүдийн үндсэн газрууд байрлахаар төлөвлөгдсөн байна.

Нийслэл хотын микрорайнууд нь зөвлөлтийн ба социалист орнуудын хот байгуулалт, иргэний барилга байгуулалтын хамгийн сүүлийн зураг төслүүдээр баригдаж байна.

1972-12-20-нд Сайд нарын Зөвлөлийн 496 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 400000 орчим суугчтай байхаар бодож боловсруулсан техник- эдийн засгийн үндэслэлийг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө зохиох үндэс болгон баталжээ

1971-1973 онд Улаанбаатар хотод ЗХУ-ын тусламжаар баригдсан 50000 хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууц, соёл, ахуй үйлчилгээний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах засгийн газрын комиссыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дарга Балбар даргатайгаар томилжээ.

1975-5-23-нд Сайд нарын Зөвлөлийн 253 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны харьяа зам, далан суваг ашиглалтын конторыг барилга трестийн төвөийн замын ангитай нэгтгэж Улаанбаатар хотын замын барилга, ашиглалтын контор болгон зам, гүүрийн барилга трестийн төвийн замын ангитай нэгтгэж, Улаанбаатар хотын замын барилга, ашиглалтын контор болгон зам, гүүрийн трестийн харьяанд ажиллуулахаар зам, гүүрийн барилга трестийг барилга, барилгын материалын үйлдвэрийн яам, Улаанбаатар хотын захиргааны хоёрдмол удирдлаганд ажиллуулахаар тогтоосон.

1975 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтын тухай илтгэлд: Улаанбаатарын асфальт бетон заводыг өргөтгөх, барилгын машин механизмын засварын газрыг ашиглалтад оруулна гэжээ.

1976-2-11- нд Сайд нарын Зөвлөлийн 20 дугаар захирамжаар Улаанбаатар хотыг 1976-2000 онуудад хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний материалд улсн экспертиз хийх комиссыг Дэмчигсүрэнгээр даргалуулан томилжээ.

1976-8-12-нд Сайд нарын Зөвлөлийн 275 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2000 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баталжээ.

“Нийслэл хотыг төлөвлөгөөтэйгээр өөрчлөн барьж байгуулах ажил 1930 –аад оноос тавигдан шинжлэх ухаан, техник эдийн засгийн үндэслэлтэй анхан хэтийн төлөвлөгөө 1950-иад оноос хэрэгжин Улаанбаатар хотыг хөгжүүлэх анхдугаар ерөнхий төлөвлөгөө нь 15-20 жилийн хугацаатай зохиогдсон.